

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Оршил

Үндэсний геологийн албаны /цаашид “алба” гэх/ үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан геологи, эрдэс баялгийн салбарын нэгдсэн бодлого, бүртгэл мэдээлэл, стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратегийн болон зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Ашигт малтмлын тухай хууль, Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоол, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын 2022 оны А/35, А/87 дугаар тушаал, Аудитын ерөнхий газрын 2021 оны 26 дугаар дүгнэлтийг тус тус үндэс болгов.

1.3 Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын тосны тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай
- Мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Бусад хууль тогтоомж

1.4 Арга зүй


Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн үйл

ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар"-т нийцүүлэн боловсруулсан болно.

1.5 Үндэсний геологийн албаны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь:

Үндэсний геологийн алба (Зураг 1) нь Засгийн газрыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн болон хөгжлийн бүсүүдэд геологи, эрдэс баялгийн судалгаа хийх замаар

- ашигт малтмалын мэдээлэл, газрын доорх усны геологийн судалгаа, газар хөдлөл, хөрсний гулсалт гэх зэрэг байгалийн гамшигт өртөх төлөв байдал;
- экологи-геологийн аюулгүйн үнэлгээ;
- авто болон төмөр зам, эрчим хүчний трассын дагуух геологи, геоэкологи;
- газрын хэвлийд болон түүний дээрх байгууламжийн геотехникийн судалгааны суурь мэдээллийг боловсруулж, мэргэжлийн зөвлөмж, дүгнэлтээр хангах үндсэн үүрэг, хариуцлага хүлээнэ;
- геологийн судалгаа, ашигт малтмалын асуудлаар хэрэглэгчдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх.



Зураг 1. Үндэсний геологийн алба. Үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Үндэсний геологийн албаны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус албаны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой ба зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ. Энэ хэрэгцээний эх үүсвэрт хамаарах үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг Зураг 2-т үзүүлэв.



Зураг 2. Үндэсний геологийн албаны удирдлага, зохион байгуулалт

ХОЁР. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн 11', 16 дугаар зүйл, тэдгээрийг дагалдах журмууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын бодлогын удирдамжийг хэрэгжүүлэхэд оршино.

2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Үндэсний геологийн алба нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана. Үүнд:

- 2.2.1 Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах;
- 2.2.2 Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах;
- 2.2.3 Геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа, шинжилгээний ажлуудыг төлөвлөх, эдгээрийг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагуудыг сонгох, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хүлээн авах;
- 2.2.4 Төрийн захиргааны төв байгууллагад геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох төрийн захиргааны болон судалгааны байгууллагатай гидрогеологи, геофизик, геоэкологи, мөн түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны эрлийн, гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын талбайд хамаарах мэдээллээр архивын сан хөмрөгөө баяжуулан, харилцан үйлчилгээ үзүүлэх;

- 2.2.5 Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг нууцад хамааруулснаас бусад мэдээллээр мэдээллээр хангах;
- 2.2.6 Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн тэнцэл гаргах;
- 2.2.7 Гадаад орнууд, олон улсын геологийн албад, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх;
- 2.2.8 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийсэн ордод ашиглалт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нөхөн төлөх зардлыг тооцох.

2.3 Үйл ажиллагааны эрхэм зорилго

Геологийн шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллээр дамжуулан үндэсний тогтвортой хөгжлийг хангах.

2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үндэсний геологийн алба нь эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.4.1 Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.4.2 Геологи, тектоник, стратиграфи, магматизм, тандан судлал, геоэкологи, гидрогеологи, грунт-геотехник, гео-гамшиг гэх зэрэг төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны санал боловсруулах, судалгаа-шинжилгээ хийх, бүтээл хэвлүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр явуулах төслийг удирдан чиглүүлэх, геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах;
- 2.4.3 Нутаг дэвсгэрийн хэмжээнд үнэт, өнгөт, хар, ховор металл, металл бус, шатах болон энергийн түүхий эд зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын чиглэлээр суурь судалгааны ажлыг төлөвлөх, эрхлэх, минерагений судалгаа, шинжилгээ хийх, бүх шатны эрлийн ажлыг гүйцэтгэж эрдэс баялгийн хэтийн төлөвийг тодорхойлох, геологи-үйлдвэрлэлийн төлөвлөлт, бүтээл хэвлүүлэх, бусад төсөл гүйцэтгэгчийг удирдлагаар хангах, эрдэс баялгийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах;
- 2.4.4 2.4.2, 2.4.3-т заасан суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлтийг эдийн засгийн үндэслэлтэй хийх нөхцлийг бүрдүүлж үнэлгээний суурь түвшинг тогтоох, геологи-эдийн засгийн үнэлгээ, харьцуулсан судалгааг явуулж, тогтмол шинэчлэн боловсруулах, хайгуулын ажилд улсын төсвөөс зарцуулсан зардлыг тооцох;
- 2.4.5 Геологи, эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, ашигт малтмалын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөн хийх, тэнцэл гаргах;
- 2.4.6. Геологи, эрдэс баялгийн салбарын хэвлэмэл болон цахим баримтыг Газрын хэвлийн тухай хууль, Архивын тухай хуулийн дагуу хадгалах, хамгаалах, нөхөн бүрдүүлэх, ашиглах, нэгдсэн тайлан мэдээлэл гаргах.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Үндэсний геологийн албаны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дараах гол зорилтууд (Зураг 3)-ыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1 Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.1.1 Төрийн захиргаа, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах;
- 2.5.1.2 Албаны эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.5.1.3 Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, төсвийн гүйцэтгэлийг хянах, хэрэгжилтийг хангах;
- 2.5.1.4 Геологийн судалгаанд холбогдох хууль тогтоомж, түүний дагалдах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, албаны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд журам боловсруулах;
- 2.5.1.5 Албан тушаалтнуудад төрийн албаны мэргэшлийн сургалт, давтан сургалтыг зохион байгуулах;
- 2.5.1.6 Геологи, эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд бүхий л арга хэрэгслээр сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл болон статистик, тоон мэдээллийг боловсруулан түгээх, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- 2.5.1.7 Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах дотоодын хяналтын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох.

2.5.2 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.2.1 Геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, тандан судлал, геотехник болон грунт, гамшгийн судалгааны ажил, төслүүдийн төлөвлөгөө, геологийн даалгавар боловсруулах, дээрх чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулах;
- 2.5.2.2 Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа 2.5.2.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх;
- 2.5.2.3 Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд чулуулгийн стратиграфи, палеонтологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, төслийн хүрээнд гарсан зургийг редакцияар хангах, геологийн нэр томъёоны ойлголтыг нэгтгэх ажлыг удирдан хэрэгжүүлэх;
- 2.5.2.4 Бүх төрлийн геологийн судалгааны ажлын бодлого, эрхзүйн орчин, төлөвлөлт, төсөвлөлтийг боловсоронгуй болгох санал зөвлөмж боловсруулах.

2.5.3 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.3.1 Үнэт, өнгөт, хар, шатах гэх зэрэг мөн өндөр технологийн түүхий эд, үйлдвэрийн түүхий эд, энергийн түүхий эд, металлогени-минерагений чиглэлээр суурь судалгааны ажлыг төлөвлөх, эрхлэх, төслүүдийн төлөвлөгөө, геологийн даалгавар боловсруулах, төслүүдийг сонгон шалгаруулах, дээрх чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 2.5.3.2 Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа 2.5.3.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар судалгааны ажлыг удирдан чиглүүлэх;
- 2.5.3.3 Нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх төрлийн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнг судлан, минерагений судалгаа, шинжилгээ хийх, бүх шатны

эрлийн ажлыг хариуцан гүйцэтгэж, эрдэс баялгийн санг баяжуулан, хэтийн төлвийг тодорхойлох, холбогдох зургийг Улсын зургийн редакцияар хянуулах, ашигт малтмалын нэр томъёоны нэгдсэн ойлголтод санал оруулах, бүтээл хэвлүүлэх;

- 2.5.3.4 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамаарах төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэж байгаа ашигт малтмалын хайгуулын ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- 2.5.3.5 Нэгжийн чиг үүргийн хүрээнд төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах.

2.5.4 Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.5.4.1 Геологи, эрдэс баялгийн чиглэлээр улсын төсвөөс санхүүжих суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлт, төлөвлөгөөнд төсөөлөгдөх зардлыг эдийн засгийн үндэслэлтэй тогтоох, мөрдүүлэх;
- 2.5.4.2 Төлөвлөгөөнд тусгах үнэлгээний суурь түвшинг тогтмол шинэчилж, зах зээлийн харьцуулсан судалгаанд үндэслэн боловсруулах, тайлагнах;
- 2.5.4.3 Геологи-үйлдвэрлэлийн ажлын санхүүжилт, хөрөнгө оруулалт, геологи-хайгуулын эдийн засгийн үнэлгээ хийх, судалгааг явуулах;
- 2.5.4.4 Нэгжийн чиг үүргийн хүрээнд олон улсын ижил төстэй байгууллагуудын геологи-үйлдвэрлэлийн ажлын эдийн засгийн үнэлгээг судалгааны чиглэл, эрдэс баялгийн төрөл бүрээр нарийвчлан судалж, товхимол хэвлүүлэх, дотоодын эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулж, зөвлөмж гаргах;
- 2.5.4.5 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон, улсын бүртгэлд бүртгэсэн орд газраас олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хайгуулын ажилд улмын төсвөөс зарцуулсан карлыг тооцон, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

2.5.5 Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.5.1 Геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрлийн ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж төрөлжсөн болон нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах;
- 2.5.5.2 Мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах болон хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц мэдээллийн технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгож байнга сайжруулах;
- 2.5.5.3 Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайн геологийн мэдээллийг бэлтгэн, геологи, уул уурхайн асуудал геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 2.5.5.4 Монгол Улсын нутаг дэвсгэрт илрүүлж, тогтоосон ашигт малтмалын орд, түүний нөөцийг бүртгэх, Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийг хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, тэдгээртэй холбоотой журам, зааврыг боловсруулах;
- 2.5.5.5 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эрдэс баялгийн чадавхийг үнэлэх, ашигт малтмалын ашиглалтын хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор нөөцийн хөдөлгөөнийг хийх, нөөцийн тэнцлийг гаргах, мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах.

2.5.6 Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

- 2.5.6.1 Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг холбогдох хууль, тогтоол, журмын дагуу эрхлэх, архивын үйлчилгээг боловсронгуй болгох, хяналт тавих;
- 2.5.6.2 Архивын үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийг чадавхжуулах;
- 2.5.6.3 Архивын үйл ажиллагааг олон улсын ижил төстэй архивын сан хөмрөгтэй харьцуулан судлах, нэгдсэн бүртгэлд гишүүнчлэлээр элсэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.5.6.4 Архивын үйл ажиллагааг тогтмол сайжруулах чиглэлээр бодлогын санал боловсруулан, төлөвлөлийг сайжруулж, хүний нөөцийг чадавхжуулах;
- 2.5.6.5 Архивын баримтыг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж, хамгаалалтын хувь үүсгэх;
- 2.5.6.6 Газрын хэвлийн тухай хууль, Архивын тухай хууль тогтоомжуудын хүрээнд газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэн хүлээн авах, тайлан мэдээг тогтмол гаргах;
- 2.5.6.7 Архивын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

2.6 Үйл ажиллагааны зорилт

Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны гол зорилт бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилт (чиг үүрэг)-ыг ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.7 Үйл ажиллагааны стратегийн загвар

Албаны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загвар (Зураг 3)-ыг дор дурдсанаар тодорхойлсон байна.

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА(БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИ ЗАГВАР

Эрхэм зорилго	Үндсэн үйл ажиллагааны	Үйл ажиллагааны гол зорилт
Геологийн шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллээр дамжуулан үндэсний тогтвортой	Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх	- Төрийн захиргаа, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах; - Албаны эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх; - Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төслүүдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, төсвийн гүйцэтгэлийг хангах, хяналт тавих; - Геологийн судалгаанд холбогдох хууль тогтоомж, түүний дагалдах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, албаны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд журам боловсруулах; - Албан тушаалтнуудад төрийн албаны мэргэшлийн сургалт, давтан сургалтыг зохион байгуулах; - Геологи, эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд бүхий л арга хэрэгслээр сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл болон статистик, тоон мэдээллийг боловсруулан түгээх, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах дотоодын хяналтын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох.
	Геологи, тектоник, стратиграф, магматизм, тандан судлал, геоэкологи, гидрогеологи, грунт-геотехник, гео-гамшиг гэх зэрэг төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны санал боловсруулах, судалгаа-шинжилгээ хийх, бүтээл хэвлүүдэх, улсын төсвийн хөрөнгөөр явуулах төслийг удирдан чиглүүлэх, геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах	- Геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, тандан судлал, геотехник болон грунт, гамшигын судалгааны ажил, төслүүдийн төлөвлөгөө, геологийн даалгавар боловсруулах, дээрх чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулах; - Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа 2.5.2.1-д заасан ажлын үйл ажиллагааг эрхлэх, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт, шийдвэр гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх; - Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд чулуулгийн стратиграф, палеонтологийн асуудлыг удирдах, ажил, төслийн хүрээнд гарсан зургийг редакцияар хангах, геологийн нэр томъёоны нэгдсэн ойлголтыг удирдан хэрэгжүүлэх; - Геологийн зураглал, тектоник, стратиграф, магматизм, тандан судлал, геоэкологи, гидрогеологи, грунт-геотехник, гео-гамшигын зэрэг төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал зөвлөмж боловсруулах; - Нэгжийн үйл ажиллагаанд хамаарах ажлын хүрээнд гадаад болон олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төслийг удирдан хэрэгжүүлэх, судалгаа-шинжилгээ хийх, холбогдох бүтээл хэвлүүлэх, салбарын үйлдвэрлэл-шинжлэх ухааны хөгжлийн бодлогын санал боловсруулах.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд үнэт, өнгөт, хар, ховор металл, металл бус, шатах болон энергийн түүхий эд зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын чиглэлээр суурь судалгааны ажлыг төлөвлөх, эрхлэх, минерагений судалгаа, шинжилгээ хийх, бүх шатны эрлийн ажлыг гүйцэтгэж эрдэс баялгийн хэтийн төлвийг тодорхойлох, геологи-үйлдвэрлэлийн төлөвлөлт, геологи-эдийн засгийн үнэлгээ судалгааг явуулж, бүтээл хэвлүүлэх, бусад төсөл гүйцэтгэгчийг удирдлагаар хангах, эрдэс баялгийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах, суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлтийг эдийн засгийн үндэслэлтэй хийх нөхцлийг бүрдүүлж үнэлгээний суурь түвшинг тогтоох, геологи-эдийн засгийн үнэлгээ, харьцуулсан судалгааг явуулж, тогтмол шинэчлэн боловсруулах

- Үнэт, өнгөт, хар, шатах гэх зэрэг мөн өндөр технологийн түүхий эд, үйлдвэрийн түүхий эд, энергийн түүхий эд, металлгени-минерагений чиглэлээр суурь судалгааны ажлыг төлөвлөх, эрхлэх, төслүүдийн төлөвлөгөө, геологийн даалгавар боловсруулах, төслүүдийг сонгон шалгаруулах, дээрх чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулах;
- Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа 2.5.3.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар судалгааны ажлыг удирдан чиглүүлэх;
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх төрлийн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнг судлан, минерагений судалгаа, шинжилгээ хийх, бүх шатны эрлийн ажлыг хариуцан гүйцэтгэж, эрдэс баялгийн санг баяжуулан, хэтийн төлөвийг тодорхойлох, холбогдох зургийг Улсын зургийн редакцияар хянуулах, ашигт малтмалын нэр томъёоны нэгдсэн ойлголтод санал оруулах, бүтээл хэвлүүлэх;
- Геологи, уул уурхайн Төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэж буй Геологи-хайгуулын ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих,
- Төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах.
- Геологи, эрдэс баялгийн чиглэлээр улсын төсвөөс санхүүжих суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, төлөвлөгөөнд төсөөлөгдөх зардлыг эдийн засгийн үндэслэлтэй тогтоох, мөрдүүлэх;
- Төлөвлөгөөнд тусгах үнэлгээний суурь түвшинг тогтмол шинэчилж, зах зээлийн харьцуулсан судалгаанд үндэслэн боловсруулах, тайлагнах;
- Геологи-үйлдвэрлэлийн ажлын санхүүжилт, хөрөнгө оруулалт, геологи-хайгуулын эдийн засгийн үнэлгээ хийх, судалгааг явуулах;
- Нэгжийн чиг үүргийн хүрээнд олон улсын ижил төстэй байгууллагуудын геологи-үйлдвэрлэлийн ажлын эдийн засгийн үнэлгээг судалгааны чиглэл, эрдэс баялгийн төрөл бүрээр нарийвчлан судалж, товхимол хэвлүүлэх, дотоодын эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулж, зөвлөмж гаргах.

Геологи, эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг хуулиар хориглоогүй мэдээллээр хангах, ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн тэнцэл гаргах

- Геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрлийн ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, боловсруулалт хийж төрөлжсөн болон нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах;
- Мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах болон хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц мэдээллийн технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгож байнга сайжруулах;
- Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэх геологи, хайгуулын судалгааны ажилд сонгон шалгаруулалтаар шинээр олгох талбайд хийгдсэн геологийн судалгааны үр дүнгийн төрөлжсөн болон нэгдсэн мэдээллээр холбогдох төрийн захиргааны байгууллагыг хангах;
- Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээн дэх эрдэс баялгийн чадавхийг тодорхойлох зорилго бүхий нөөцийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

Холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллагатай геомэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх асуудлаар хамтран ажиллах.

Геологи, эрдэс баялгийн салбарын хэвлэмэл болон цахим баримт материалыг Газрын хэвлийн тухай хууль, Архивын тухай хуулийн дагуу хадгалах, хамгаалах, нөхөн бүрдүүлэх, ашиглах, нэгдсэн тайлан мэдээлэл гаргах

- Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг зохих хууль, тогтоол, журмын хүрээнд гүйцэтгэх зорилго бүхий архивын үйлчилгээг боловсронгуй болгох, зохион байгуулах;
- Архивын үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийг чадавхжуулах;
- Архивын баримтыг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж, хамгаалалтын хувь үүсгэх;
- Газрын хэвлийн тухай хууль, Архивын тухай хууль тогтоомжуудын хүрээнд газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэн хүлээн авах, тайлан мэдээг тогтмол гаргах;
- Архивын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Зураг 3. Үндэсний геологийн албаны стратеги загвар

ГУРАВ. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1 Бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад баримтлах зарчим

Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоог боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав. Үүнд:

- 3.1.1 Үндэсний геологийн албаны ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус газрын үйл ажиллагааны стратегийн зорилттой нийцсэн байх;
- 3.1.2 Бүтцийн нэгжүүдийн нэр нь тэдгээрийн үйл ажиллагааны стратегийг тусгасан байх;
- 3.1.3 Бүтцийн хувьд энгийн байх;
- 3.1.4 Бүтцийн нэгжүүдийг аль болох хялбар удирдах, үйл ажиллагааг нь хянах боломжтой байх;
- 3.1.5 Улс төржихгүй байх зарчим /тухайн албаны албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн нөлөөлөлд автахгүй байх/;
- 3.1.6 Бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхыг бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх;
- 3.1.7 Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;
- 3.1.8 Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагаа явуулах (үйл ажиллагааны ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх);
- 3.1.9 Албаны удирдлага, албан хаагчид мэргэшсэн, шуурхай бүтээлч, чирэгдэлгүй байх.

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчимд үндэслэн тус газар нь зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжүүдтэй байна. Үүнд:

- 1. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж;
- 2. Геологийн судалгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж;
- 3. Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж;
- 4. Геологи, эрдэс баялгийн мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж;
- 5. Геологи, эрдэс баялгийн баримттай холбоотой асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж.

3.3 Зохион байгуулалтын бүтэц

Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг (Зураг 3)-ийг тодорхойлж байна. Үүнд:

3.3.1 Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын

манлайллыг хангах, байгууллагын санхүүгийн асуудлыг шийдвэрлэх үндсэн үүргийг хүлээж, байгууллагын үйл ажиллагаанд удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, аж ахуй, нийтлэг үйлчилгээг хүн бүрт хүргэж үйлчлэх, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлуудыг зохион байгуулах, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох, үр дүнг үнэлэн дүгнэх, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгох, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь албаны дарга болон нэгжийн удирдлагуудад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, нэгжүүдийн хоорондын ажлын уялдаа холбоог хангах, удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, байгууллагын санхүү, бүртгэлийг хөтлөн, санхүүгийн тайлан бэлтгэх, ажилтнуудыг чадваржуулах, мэргэжүүлэх, дадал, туршлага эзэмшүүлэх замаар хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Мөн байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг хууль, эрх зүйд нийцүүлэх, салбарын хууль тогтоомжоор зохицуулагдах байгууллагын үйл ажиллагааны дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үндэсний геологийн албаны ажилтнуудын цаг ашиглалтыг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналт шалгалтын тогтолцоог буй болгох, удирдлагын шийдвэр, бодлого журмын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, салбарын холбогдолтой мэдээ, мэдээлэл, статистик тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулах, удирдах дээд байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах, сургалт, давтан сургалтын ажлыг зохион байгуулах, албаны даргад болон нэгжүүдийн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний геологийн албаны дарга, албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга (ТНБД), төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.2 Геологийн судалгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн чиг үүрэг:

Энэ нэгж нь Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, геоэкологи, гидрогеологийн региональ судалгааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын удирдамжийн дагуу гүйцэтгэнэ. Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт, шийдвэр гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлнэ. Улс орны хэмжээнд геологийн судалгааны бодлогын хэрэгжилтийг тодорхойлох ажлыг зохион

байгуулах, тэдгээрт судалгаа хийхийг санал болгох, геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны төслүүдийн геологийн даалгавар боловсруулах, геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, зөвлөлгөө өгөх, эрх зүйн орчны судалгаа хийх, сонгон шалгаруулалтаар зарлах талбайн геологийн судалгааны үр дүнгийн талаарх материалуудыг бэлтгэж, төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах, төслийн гүйцэтгэлд хяналт тавих үндсэн үүрэгтэй байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд чулуулгийн стратиграфи, палеонтологийн асуудлыг удирдах, ажил, төслийн хүрээнд гарсан зургийг редакциар хангах, геологийн нэр томъёоны нэгдсэн ойлголтыг удирдан хэрэгжүүлнэ. Нэгжийн үйл ажиллагаанд хамаарах ажлын хүрээнд гадаад болон олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төслийг удирдан хэрэгжүүлэх, судалгаа-шинжилгээ хийх, холбогдох бүтээл хэвлүүлэх, салбарын үйлдвэрлэл-шинжлэх ухааны хөгжлийн бодлогын санал боловсруулна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний геологийн албаны дарга, албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, түүний геологийн бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.3. Геологи, эрдэс баялгийн судалгааны төлөвлөлт, эдийн засгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн чиг үүрэг:

Энэ нэгж нь Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд нутаг дэвсгэрийн ашигт малтмал, эрлийн ажил, металлогений судалгааг Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын удирдамжийн дагуу гүйцэтгэж, улс орны эрдэс баялгийн чадавхыг тодорхойлох ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хүдрийн бүс, зангилгаа, талбайг ялган, тэдгээрт судалгаа хийхийг санал болгох, геологи, ашигт малтмалын судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ашигт малтмалын геологийн судалгааны төслүүдийн геологийн судалгааны даалгавар боловсруулах, ажлыг удирдан чиглүүлэх, зөвлөлгөө өгөх, эрх зүйн орчны судалгаа хийх, ашигт малтмалын геологийн судалгааны үр дүнгийн талаарх материалуудыг бэлтгэж удирдлагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах үндсэн үүрэгтэй байна.

Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд тогтоогдсон ордыг ашиглаж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хайгуулын ажилд улсын төсвөөс зарцуулсан сардлыг тооцох, олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлүүлэхэд холбогдох төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэн ажиллана.

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад оролцоно.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний геологийн албаны дарга, албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, түүний геологийн бодлого төлөвлөлт, зохицуулалтын газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байна.

3.3.4. Геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан, технологийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгжийн чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд Эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрөл, шатны ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хөтлөх болон хэрэглэгчдийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгон байнга сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн бүх төрлийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдон, сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг боловсруулан, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах асуудал хамаарна.

Монгол улсын нутаг дэвсгэрт илрүүлж, тогтоосон ашигт малтмалын орд, түүний нөөцийг бүртгэх, ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийг хөтлөх, Монгол Улсын эрдэс баялгийн чадавхыг үнэлэх, ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор нөөцийн хөдөлгөөнийг хийх, нөөцийн тэнцлийг гаргах, мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах, боловсруулалт хийх, хэрэглэгчийг мэдээллээр хангаж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний геологийн албаны дарга, албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд, геологийн судалгааны ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, УУХҮЯ-ны газар, хэлтсүүд, Сангийн яам, геологи, эрдэс баялгийн судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, иргэд, аж ахуй нэгж, олон улсын байгууллага байна.

3.3.5 Геологи, эрдэс баялгийн баримттай холбоотой асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрт хийгдэх геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрөл, шатны ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, төрөлжсөн болон нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах үндсэн үйл ажиллагаа явуулна. Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг зохих хууль, тогтоол, журмын хүрээнд гүйцэтгэх, архивын үйлчилгээг боловсронгуй болгон зохион байгуулна.

Уг ажлыг Газрын хэвлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулна. Архивын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үндэсний геологийн албаны дарга, албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн ажилтнууд, геологийн судалгааны ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд байх ба шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, дэд сайд, УУХҮЯ-ны газар, хэлтсүүд, Сангийн яам, геологи, эрдэс баялгийн судалгааны ажил эрхэлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, Байгаль орчин, аялал

жуулчлалын яам, бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага байна.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН

4.1. Үйл ажиллагааны стратеги тодорхой болсноор хийх ажлын чиглэл, хамрах хүрээ, дараалал тодорхой болж, үр өгөөж дээшилнэ.

4.2. Албаны ажилтнуудын ажлын чиг үүрэг тодорхой болж, өөрийгөө дайчлах, үр өгөөжтэй ажиллах боломж бүрдэнэ.

--oOo--

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгаа, эдийн засгийн

үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Амаржаргал

Холбоо барих утас: 70182011

Цахим шуудан: a.amarjargal@ngs.gov.mn